

БАТЛАВ:
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.СУГАР.



2019 оны 07 дугаар сарын 8-ны өдөр

**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**ЦАГААН-ОВОО
2019**

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

2019.07.19

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **НАРИЙНТЭЭЛ БОЛОН БАЯНТЭЭГ БАГЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ**

Төслийн дугаар: **№ӨВАНТСЗДТГ/201901003/**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

1. **Нарийнтээл Сумын Засаг Даргын Тамгын Газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Нарийнтээл сумын эмнэлэг болон баянтээг багийн эмнэлэгүүдэд тоног төхөөрөмж худалдан авах** –ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000** /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Дотоодын давуу эрхийн зөрүү **тооцоно**.

2. Үнийн саналыг **2019 оны 07 дугаар сарын 26-ны 10 цаг 00 минут-аас** өмнө **Сумын Засаг Даргын Тамгын газар 2-р давхар мал эмнэлгийн тасаг** хаягаар ирүүлнэ.
4. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 07 дугаар сарын 26** ны өдрийн **10 цаг 50 минут**-д нээнэ.

Нарийнтээл Сумын Засаг Даргын Тамгын Газар 88050400
88030049

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт				
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн 2 /хоёр / жилийн буюу 2017, 2018 оны санхүүгийн тайлан - Ижил төстэй ажил гүйцэтгэсэн сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл гэрээний хуулбар захиалагч талын тодорхойлт: - Сүүлийн 2 жилд борлуулалтын орлого нь тухайн багцад санал болгож буй үнийн дүнгийн 10%-иас багагүй байх <p>Бусад нэмэлт шаардлага; Харилцагч банкуудын өр, зээлгүй тодорхойлолт, Татвар, Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт, Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар дансны үлдэгдэлийн баталгаа</p>				
ТӨӨЗ 2.1	<p>Тендерт оролцогч нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ. 2. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх <p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газар Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: Нарийнтээл сум Цагаан-овоо баг Засаг даргын Тамгын газар 2-р давхарт Мал эмнэлгийн тасгийн өрөө</p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>				
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Нарийнтээл сум Цагаан-Овоо баг Засаг даргын Тамгын газар Давхар болон өрөөний дугаар 2-р давхарын Мал эмнэлгийн тасгийн өрөө Огноо: 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Цаг: 10 цаг 50 минут</p>				
ТӨӨЗ 6.1	<p>Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>				
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <table border="0" style="width: 100%;"> <tr> <td style="width: 80%;">Багц 1 Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж</td> <td style="text-align: right;">35,000,000</td> </tr> <tr> <td>Багц 2 Баянтээг багийн тоног төхөөрөмж</td> <td style="text-align: right;">5,000,000</td> </tr> </table>	Багц 1 Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж	35,000,000	Багц 2 Баянтээг багийн тоног төхөөрөмж	5,000,000
Багц 1 Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж	35,000,000				
Багц 2 Баянтээг багийн тоног төхөөрөмж	5,000,000				

Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: *Сумын эмнэлэг болон баянтээг багын эмнэлэг тоног төхөөрөмж худалдан авах*
2. Стандарт: Чанарын стандартад нийцсэн тоног төхөөрөмж.
3. Баглаа, боодол: **Барааны савлалт баталгаажсан хэмжүүртэй байх / мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй байх/. Сав баглаа боодол нь гэмтээгүй.Тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх**
4. Бараа хүргэх газар: Нарийнтээл сумын Цагаан-Овоо 4-р баг Эрүүл мэндийн төв болон Баянтээг баг
5. Нарийнтээл сумын Эрүүл мэндийн төв, Баянтээг багийн эмнэлгийн нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт

Багц -1				
№	Тоног төхөөрөмжийн нэр	Техник үзүүлэлт	Тоо ширхэг	Хаана хэрэглэгдэх
1	Биохимийн хагас автомат анализатор	Нээлттэй урвалжийн системтэй, урвалж уусмалаар байх LCD дэлгэцтэй Хэмжилтийн параметрууд: -Liver: ALT, ALP, GGT, TP, Alb, TBIL, DBIL, -Heart: LDH, CK, CK-MB, AST, a-HBDH -Lipids: CHO, TG, HDL_C, LDL_C -Lipoprotein: apo A1, Apo B, Lp(a) -Kidney: BUN,CRE, UA -Ion: Na, Mg, Ca, K, P, CL -other: CP, AMS, LIP, GLU, LgG, LgM, C3, C4, CRP Температурын хяналт: 15 ^o -32 ^o C (±0.10C хувьсагч) Чийгшил <80% Сорьцийн төрөл: ийлдэс, плазма, цус, шээс бусад Тэжээлийн хүчдэл: 100-240V/50Гц Санах ой- сүүлийн 2000 -с доошгүй өвчтөний хариу Өөр дээрээ суурилсан хэвлэгчтэй Өөртөө дотоод хяналт хийх боломжтой	1	Нарийнтээл сумын Эрүүл мэндийн төв
2	Шээсний анализатор	Урвалжийн төрөл нээлттэй системтэй байх Хүчин чадал: 60 сорил/ цаг-с доошгүй LCD дэлгэцтэй Урвалж: туузан Зураасан код уншигчтай Санах ой: 1000-с доошгүй өвчтөний хариу	1	Нарийнтээл сумын Эрүүл мэндийн төв

		<p>Сорьц төрөл: шээс Өөрөө хэвлэгчтэй Тэжээлийн хүчдэл: 12V, 240V ±10 50/60Гц Ажиллах орчин: Температурын хяналт: 15°-32°C (±0.10C хувьсагч) Чийгшил <80% Үзүүлэлтүүд: цус, билирубин, уробилиноген, кетон, глюкоз, уураг, нитрит, лейкоцит, рН, хувийн жин, аскорбины хүчил, микроальбумин USB, интернет холболттой</p>		
3	Иммунологи шинжилгээний анализатор	<p>Мэдрэгчтэй дэлгэцтэй Сорьц төрөл: Бүхэл цус, ийлдэс, цусны сийвэн, өтгөн Өөр дээрээ принтертэй Дотоод, гадаад хяналт хийх боломжтой Санах ой: 1000-с доошгүй шинжилгээний хаоюу Тэжээлийн хүчдэл: 100-240v, 50- 60гц Үзүүлэлтүүд: - зүрхний өвчлөл cardiac triple, D- Dimer, myoglobin, Tn-I, NT-proBNP -Хавдар маркер PSA, AFP, iFOB -Сахар Hba1C, -Гормон TSH, T3,T4, -халдвар CRP, ASO, H.pylory SA, Үе мөчний өвчлөл RF IgM, Anti- ССР Бусад Ferritin, Vitamin D</p>	1	Нарийнтээл сумын Эрүүл мэндийн төв
4	Хаш чулуун ор	<p>Хүний биеийн нурууны дагуух гол цэгүүдийг тодорхойлж алцаал тайлах, физик эмчилгээ, стресс тайлж, булчингуудыг суллаж, цусны эргэлтийг сайжруулах үйлчилгээтэй байа Өөртөө удирлагатай Цахилгаан тэжээл 220в/мг</p>	1	Нарийнтээл ЭМТ
5	Хэт авиан өндөр, жин хэмжигч	<p>Хэт авиан өндөр, жин хэмжигч, даац 300кг, нарийвчлал 50гр, БЖИ бодох боломжтой Автомат мэдрэгчтэй LCD дэлгэцтэй Зөөж тээвэрлэх боломжтой, эвхэгддэг байх тавцан 375*275мм</p>	1	Нарийнтээл ЭМТ

6	Вакум уутны ам наагч	Хүчин чадал 80м/цаг Цахилаан тэжээл 220в/55һя Чадал 2,5KW Ажиллах температур 0°-180°С	1	Нарийнтээл ЭМТ
7	Искра -1	Гаргах цахилгаан даралт : 0-3000V хүртэл тохируулдаг байх 4-с дээш электродтой байх Цахилгаан давтамж :50гц±2гц Гаргах цахилгааны урсгалын хэмжээ: 6,5мА±10% Чадал 600Вт Цахилгаан тэжээл 220в/50мА	1	Нарийнтээл ЭМТ
8	отоскоп	Микроконтроллер суурилсан шинжилгээний багаж гэрэл үүсгэгчтэй	1	Нарийнтээл ЭМТ
9	Булчин сэргээх аппарат	Керамик бумба болон наалтын тусламжтайгаар хэсэг газарт нам давтамжийн цахилгааны үүсгүүрээр , цусан хангамж сайжруулах булчинд үйлчлэх аппарат өвдөлт намдаах үйлдэл үзүүлэх Тэжээлийн хүчдэл : 220в/60гц Батерей: DC 9V(1.5*6) Сувгийн тоо :4-с дээш Давтамж: 1-300гц	1	Нарийнтээл сумын ЭМТ
10	Хажуугийн гэрэл	Диаметр 100-150мм Лампны чадал :30вт Хүчдэл: 220в/50-60гц	1	Нарийнтээл сумын ЭМТ
11	Цахилгаан зүүний аппарат	Гүйдлийн гаралт/ дээд гаралт: 10А Сонгож хэрэглэх давтамжууд : 1,5,10,25,50,100hz Эмчилгээний хугацаа: 5,10,15,20,30,40,50,60,90	1	Нарийнтээл сумын ЭМТ
12	Нярайн жин, өндөр үзэгч хамт	Нярайн жин: 0-25кг хүртэл жигнэх боломжтой Өндөр хэмжигчтэй Электрон,LCD дэлгэцтэй	1	Нарийнтээл сумын ЭМТ,
13	Эмчилгээ, багаж хэрэгслийн тэргэнцэр	Зэвэрдгүй ган, метал тавцантай, хашлагтай тавиуртай Дуу чимээгүй, дугуйт Өөртөө хувингийн тавиуртай Давхар тавиуртай 2 татдаг шүүгээтэй Хэмжээ Өр670* өн850*D450мм Түрж явах бариултай	1	Баянтээг багийн эмнэлэг
Багц-2				

1	Зөөврийн автоклав	Багтаамж: 18 л-24 л Ажиллах даралт утга: 0,145-0,165Мра Ажиллах температур: 126 ⁰ -128 ⁰ С Аюулгүй даралтын хязгаар: 0,165Мра Цахилгаан тэжээл: 220В/50Гц	1	Баянтээг багийн эмнэлэг
2	Өндөр жин хэмжигч	Дижитал өндөр жин хэмжигч	1	Баягтээг багийн эмнэлэг
3	Өвчтөний хяналтын монитор	12,1 инчийн мэдрэгчтэй дэлгэцтэй EGG, SPO2, NIBP, зүрхний гаралт, IBP, температур үзэх боломжтой санах ойтой зөөврийн	1	Баянтээг багийн эмнэлэг
4	Сорох аппарат	Сорох даралт хэмгийн их утга: >90кРА Дуу чимээ: <65dB(A) Шингэн соруулах савны хэмжээ: 2500мл/2 ширхэг/ Тасралтгүй ажиллах хугацаа:30 мин	1	Баянтээг багийн эмнэлэг
5	Имфра эмчилгээний аппарат	Инфра улаан туяаны хэрэглээ: 0-250W Инфра улаан туяаннны долгионы урт: 760-3000нм Өндрийг тохируулах: 43"-63" Төрөл: хэт улаан туяа Эмчилгээний хугацаа:5-60 мин Тэжээлийн хүчдэл: 220V/50Hz Зөөвөрлөхөд тохиромжтой дугуйт хөлтэй байх	1	Баянтээг багийн эмнэлэг
6	Искра	Зөөврийн Цахилгааны тэжээл:220В/50Гцу Гаргах цахилгаан даралт: 0-1500V хүртэл тохируулж болдог Цахилгаан давтамж: 50Гц±2Гц Гарах цахилгааны урсгалын хэмжээ: 6,5мА±10%	1	Баянтээг багийн эмнэлэг
7	Нярайн жин, өндөр үзэгч хамт	Нярайн жин: 0-25кг хүртэл жигнэх боломжтой Өндөр хэмжигчтэй Электрон, LCD дэлгэцтэй	2	Нарийнтээл сумын ЭМТ, Баянтээг багийн эмнэлэг

8	Эмчилгээ, багаж хэрэгслийн тэргэнцэр	Зэвэрдгүй ган, метал тавцантай, хашлагтай тавиуртай Дуу чимээгүй, дугуйт Өөртөө хувингийн тавиуртай Давхар тавиуртай 2 татдаг шүүгээтэй Хэмжээ Өр670* өн850*D450мм Түрж явах бариултай	2	Баянтээг багийн эмнэлэг Нарийнтээл ЭМТ
---	--------------------------------------	--	---	--

6. Нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмжүүд нь баталгаат хугацаатай, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх боломжтой, лабораторийн тоног төхөөрөмжийн урвалж оношлуурыг ханган нийлүүлэх боломжтой, хямд байх, баталгаат хугацаанд болон багаж тоног төхөөрөмжийн ажиллуулах туршилтийн урвалж оношлуураар ханган нийлүүлж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, гарын авлагыг монгол хэлээр бэлтгэсэн байх, ажиллах зааварчилгааг өгч дагалдан сургах боломжтой байх. Техник ашигалалтын passbordtoi байх. Мөн баталгаат хугацаа 2 жилийн хугацаатай

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |

- 9. Алданги оногдуулах**
- 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9) 9.1. Алданги оногдуулах хувь: **[тоо]**
- Алдангийн нийт дүн: **[тоо]**

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]